



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 722

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4, дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, засаж сэлбэн ашиглах боломжгүй 5 нэрийн, нийт 13,134,800.00 (арван гурван сая нэг зуун гучин дөрвөн мянга найман зуун) төгрөгийн балансын үнэ, 7,029,796.77 (долоон сая хорин есөн мянга долоон зуун ерэн зургаан төгрөг далан долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газрын дарга Ж. Тамирт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
722... дугаар тогтоолын хавсралт

ТӨР ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ (ширхэг)	Балансын үнэ, (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Notebook саарал	2020.12.22	4,900,000.00	4,900,000.00	1	4,900,000.00	2,031,600.06	2,868,399.94
2	Зургийн аппарат Nikon D7200	2017.11.22	4,500,000.00	4,500,000.00	1	4,500,000.00	3,462,482.00	1,037,518.00
3	Хэрээсний машин	2020.06.29	935,000.00	935,000.00	1	935,000.00	291,186.35	643,813.65
4	Таб	2020.06.29	799,900.00	799,900.00	2	1,599,800.00	498,225.00	1,101,575.00
5	Аяны майхан	2020.11.09	1,200,000.00	1,200,000.00	1	1,200,000.00	746,303.36	453,696.64
Нийт үнэ						13,134,800.00	7,029,796.77	6,105,003.23
						(арван гурван сая нэг зуун гучин дөрвөн мянга найман зуу)	(долоон сая хорин есэн мянга долоон зуун ерэн зургаан төгрөг далан долоон мөнгө)	(зургаан сая нэг зуун таван мянга гурван төгрөг холрин гурван мөнгө)